

ӨМНӨХ ҮГ

Монголын Хүн Ам ба Хөгжил Нийгэмлэг, МУИС-ийн ЭЗС-ийн Хүн Амын Сургалт, Судалгааны Төвтэй хамтран НҮБ-ын ХАС-гийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “Монголын Хүн Амын Сэтгүүл”-ийн 17 дахь дугаарыг бэлтгэн, эрхэм уншигч Та бүхэнд толилуулж байна.

Сэтгүүлийн “Судалгаа” хэсгээс Ойрын 20 жилд Монгол Улсын хүн амын насны бүтцэд гарах өөрчлөлт, хандлага, насжилттай холбогдон бий болох хэрэгцээ, шаардлага, Шувууны томуу, томуугийн цартахлын талаар шийдвэр гаргагчид, хүн ам, шувууны аж ахуй эрхлэгчдийн мэдлэг, хандлага, дадал, эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн эмч, ажилтнуудын томуугийн цартахлын үед хариу арга хэмжээ авах чадвар, үйл ажиллагааг үнэлгээ, Монгол дахь бичил зээлийн хүү зэрэг хүн ам зүй, хүн амын эрүүл мэнд, хүн амын амьжиргаа, зээл авах боломжийн талаар асуудал хөндсөн судалгаануудтай танилцах болно.

“Тусгай булан”-гаа бид Монгол улсын Үндэсний Хүний Хөгжлийн Илтгэл-2007-д зориулан бэлтгэлээ. Монгол улс Үндэсний Хүний Хөгжлийн Илтгэлээ 4 дахь удаагаа бэлтгэн гаргаж байгаа бөгөөд 2007 оны илтгэл “Хөдөлмөр эрхлэлт ба ядуурал” сэдвээр бичигдсэн. Үндэсний Хүний Хөгжлийн Илтгэл нь улс орны хөгжлийн бодлогоорхи олон нийтийн хэлэлцүүлгийн чухал хэрэгсэл байдаг бөгөөд илтгэлд зориулан үндэсний илтгэлийн гол хэрэглэгчдийн нэг болох их дээд сургуулийн оюутнуудын дунд зарласан Эссэ бичлэгийн уралдаанд тэргүүн байр эзэлсэн оюутнуудын бүтээлээс толилуулж байна. Хүний хөгжлийн үзэл баримтлалын үүднээс хүн амын хөдөлмөр эрхлэлт, ядуурал, худалдаа ба хүний хөгжлийн асуудлыг оюутан залуус хэрхэн үнэлж, дүгнэж буйг уншигч Та тунгаан бодох боломжтой.

Харин “Үзэл бодол” хэсэгт хөдөө орон нутагт ажиллаж, амьдарч байгаад ирсэн залуу судлаач, мэргэжилтний хөдөөгийн хөгжил, хөдөөгийн ядуурлын асуудалд хийсэн дүгнэлт, үзэл бодлыг хэлэлцүүлж байна.

Сэтгүүлийнхээ *English* хэсэгт ХХ зууны Монгол улсын хүн ам зүйн түүх, Монгол Улсын хүн амын төрөлтөд нөлөөлөгч завсрын хүчин зүйлс, нийслэл хотын ядуурлын тархалтыг газрын зургийн аргаар тайлбарлах нь зэрэг эрдэм шинжилгээний ажлуудыг нийтэллээ.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт толилуулж буй судалгаа, эрдэм шинжилгээний ажлууд, эрдэмтэн, судлаачдын үзэл бодлын талаар эрхэм уншигч Та шүүмж, мэтгэлцээн, хэлэлцүүлэг өрнүүлэн, манай дараагийн дугаарт өөрийн материалаа ирүүлнэ гэдэгт бид итгэлтэй байна.

Энэ ялдамд, хүн ам зүй, хүн ам, хөгжлийн асуудлаар судалгаа, эрдэм шинжилгээний ажилд оюун санаагаа зориулан манай сэтгүүлд өөрийн бүтээлээ ирүүлсэн нийт эрдэмтэн, судлаачид, оюутнууддаа болон уг сэтгүүлийн дугааруудыг бэлтгэн хэвлэхэд байнгын дэмжлэг, туслалцаа үзүүлж байгаа НҮБ-ын ХАС-гийн суурин төлөөлөгчийн газарт сэтгүүлийн редакцийн хамт олон гүн талархлаа илэрхийлж байна.

Эрхэм уншигч таны оюуны мэлмий тань тэлэх болтугай.

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ